



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 04 дүгээр
Сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/01

Улаанбаатар
хот

**Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд
хийсэн дүгнэлтийг батлах**


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн хийсэн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



..... Ч.ВАНЧИН-ЭРДЭНЭ


“Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2019 оны 04 дүгээр
сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын ХЭХ 03/... тоот тогтоолын хавсралт

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ ” ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН ХИЙСЭН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ**

“Жуулчин Дюти Фрий” Хувьцаат компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг дүгнэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн дараах дүгнэлтийг гаргалаа.

“Жуулчин Дюти Фрий” ХК-ийг 2016 оны 07 сард тус компанийн хяналтын багцын хувьцааг “Таван Богд Трейд” ХХК худалдан авсан бөгөөд үүнээс хойших хугацаанд тус компанийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар байна.

Улаанбаатар вокзалын төмөр замын вокзал, Чингис хаан ОУНОБ, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Хилийн шалган нэвтрүүлэх цогцолборын салбар дэлгүүрүүдээр татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Үндэсний статистикийн хорооны тоон мэдээллээр Монгол улсад ирэх жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа төдийгүй дотоодын жуулчид ч гадагшаа аялал жуулчлах нь нэмэгдсэн учир Монгол улсын хилээр зорчигчдын тоо эрс өсөн нэмэгдсээр байгаа нь татваргүй барааны дэлгүүрийн борлуулалтад шууд нөлөөлөл үзүүлж байна.

Тус компани 2018 оны төлөвлөгөөгөөр 4.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байсан үүнээс 5.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь төлөвлөгөөгөө 114 %-д хүргэж 14 хувиар давуулж биелүүлсэн байгаа. Иймд тус компани нь бизнесийн зорилго зорилтоо биелүүлж нөөц бололцоогоо дайчлан сайн ажилласан гэж дүгнэж байна.

2019 оны зорилтод шинэ нисэх буудалд барааны дэлгүүрийн тусгай зөвшөөрөл олгох тендерийн сонгон шалгаруулалтад оролцох ажилд гол анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Улмаар шинэ нисэх буудалд татваргүй барааны дэлхийн стандарт жишигт нийцсэн дэлгүүрийн үйлчилгээг нэвтрүүлэн олон улсын зорчигчид, жуулчид болон татваргүй барааны дэлгүүрээр үйлчлүүлэх эрх бүхий этгээдэд үйлчилгээг өргөн хүрээнд үзүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөсөн байгааг тэмдэглэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/02

Улаанбаатар
хот

Компанийн 2019 оны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.16 дах хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн 2019 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлснийг хавсралтаар баталсугай.
2. 2019 оны санхүүгийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ё.Ганбатад/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



...../Ч.ВАНЧИН-ЭРДЭНЭ/